

1. АМРЫГ АЙЛТГАЖ, МЭНДИЙГ МЭДЭХ ЁС



Чи сургууль дээрээ хэн хэнтэй,
хэрхэн мэндэлдэг вэ?



Харилцан яриаг сонсоод, тохирох
зурагтай нь холбоорой.

Сайн байна уу?

-Сайн. Сонин сайхан
юутай байна?

- Тайван сайхан.

Та сайхан амарсан уу?

-Сайхан амарлаа. Чи
сайхан амрав уу?

- Сайхан амарлаа.

Сайн байцгаана уу, хүүхдүүд ээ?

-Сайн. Та сайн байна уу?

- Сайн.





Бид хичээлээ тараад гэртээ харихдаа бие биедээ юу гэж хэлдэг вэ? Ярилцаарай.

- Баяртай.
- Баяртай. Сайхан амраарай.
- Баяртай. Маргааш уулзъя.
- Багш аа, сайхан амраарай.
- Сайхан амраарай, найз аа.



Дараах дүрд орон, мэндэлж тоглоорой.

- Ангийн багш
- Сургуулийн захирал
- Ангийн найз
- Сургуулийн үйлчлэгч
- Жижүүр багш

2. ГЭГЭЭН ӨГЛӨӨ



Өглөө болж, нар мандлаа. (Хоёр гараа алдлан нар мандуулна)
Өдөр болж, нар дээр хөөрөв. (Хоёр гараа дугуйруулж нар хөөргөнө)

Орой болж, нар жаргав. (Хоёр гараа урдуураа тойруулан нарыг жаргаана)

Шөнө болж, сар гарав. (Ширээн дээрээ хоёр гараа тавьж унтана)

Өглөөний мэнд,
миний хүү. Сайхан
амрав уу?



Сайхан амарлаа.
Өглөөний мэнд, ээж ээ.
Та сайхан амарсан уу?



Зурагт тохирох мэндчилгээг хэлээрэй.



Өглөөний мэнд.



Өдрийн мэнд.



Оройн мэнд.



Тоглоом


Багшийнхаа зааврыг сонсоод ширээнийхээ найзтай мэндлээрэй

- Өглөө болж, нар мандлаа.
- Өдөр болж, нар дээр хөөрөв.
- Орой болж, нар жаргав.
- Шөнө болж, сар гарав.

3. АМАРХАН САЙН БАЙНА УУ?



Ахмад хүнтэй хэрхэн мэндэлдэг вэ?



Би ах хүн

Айлын өвөөтэй аав минь
Амар байна уу гэж золголоо
Бямба эмээтэй тааралдаад ээж минь
Бие лагшин тунгалаг уу гэж асуулаа
Ахмад настнаа хүндэлдэг
Ардын сайхан ёс бий
Өөрөөсөө ах хүнтэй
Үргэлж түрүүлж мэндлээрэй гэж
Өвөө минь бидэнд захидаг
Үгийг нь бид дагадаг



Ахмад хүнтэй хэрхэн мэндлэх ёстойг шүлгээс эшлэн ярилцаарай.



Ахмад хүнтэй мэндлэхдээ юу гэж хэлэх вэ?

Та амархан
сайн байна
уу?

Амар
байна уу,
та?

Таны
амгаланг
айлтгая!

Таны бие
лагшин
тунгалаг уу?



Өөрөөсөө ахмад хүнтэй уулзвал хэн нь түрүүлж мэндлэх вэ?



Дараах тохиолдлуудад хэрхэн мэндлэх вэ?



Эдгээр үгийн тохирох зургийг олж, харгалзах дугуйг үгийн өнгөөр будаарай.

Сайн уу?

Сайхан намаржиж байна уу?

Та сайн байна уу?

Байна уу? Сайн байна уу?





Олон найзтай
болно.



Хүмүүстэй эелдэг,
зөв мэндлэхийн ач
тус юу вэ?

Ёс журмаа мэддэг,
соёлтой хүн
болно.

Хүмүүс чамд
сайхан хандана.



Мэндийн монгол ёс

- Ахмад хүнтэй эхэлж мэндэлнэ. Хэрэв насаар дүү нь эхэлж мэндлэхгүй бол ахмад хүн ах зах хүнтэй эхэлж мэндэлж байхыг сануулна.
- Уулзаж байгаа хүнээ эгцлэн харж, эелдгээр инээмсэглэн мэндэлнэ.
- Мэндийг бүтэн өгүүлбэрээр хэлнэ.
- Мэнд бүхэнд хариулна. Жишээлбэл, Та амархан сайн байна уу? гэхэд “Сайн байна. Та амархан сайн байна уу?” хэмээн хариу мэнд мэднэ.
- Ахмад хүнтэй золгохдоо малгай хувцсаа ёсоор нь өмсөж, товчоо бүрэн товчилсон байна.
- Хүндэтгэлийн үед алгаа дэлгэн, хоёр гараа сунгаж, бөхийн “Таны амар амгаланг айлтгая” хэмээн мэнд мэднэ. Нэг өвдөг, эсвэл хоёр өвдөг сөгдөн мэнд мэдэх ёс ч бий.




Хүн бүхэнтэй эелдэг инээмсэглэн, бүтэн өгүүлбэрээр мэндэлж хэвшээрэй.

1. ЗӨВ СУУЖ СУРЦГААЯ



“Зөв суух” тоглоом тоглоцгооё. Зааврын дагуу нэг минутын турш хөдөлгөөнгүй сууж үзээрэй.



Яаж суусан нь илүү амархан байна вэ? Тохирох зургийн доор байгаа дөрвөлжнийг будаарай.



Зургийг ажиглаад, яаж зөв суух ёстойг хэлээрэй.

Зөв суух арга

Толгой тэгш.



Нуруу цэх.

Гутлын улаа шалан дээр бүтэн тавьж сууна.



Яагаад нуруу цэх, зөв суух хэрэгтэй вэ?

Нуруу өвдөхгүй.

Хичээлээ анхаарч,
сайн сурна.

Сайхан бичнэ.

Ард суугаа найзууддаа
саад болохгүй.

Нуруу цэх болно.



Дараах зургуудаас зөв сууж байгаа хүүхдийн зургийг олж доорх дөрвөлжинг тэмдэглээрэй. Хариугаа ангийнхантайгаа ярилцаарай.

